



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/390

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, "Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлогын 7.1-д тусгасан зорилт, Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/375 дугаар тушаалаар батлагдсан "Батлан хамгаалах яамнаас эрдэмтэн бэлтгэх бодлого" баримт бичиг, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалах яамнаас эрдэмтэн бэлтгэх бодлогыг 2030 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөөг нэгдүгээр, Батлан хамгаалах яамны захиалгаар Үндэсний батлан хамгаалахын их сургуульд доктор бэлтгэх журмыг хоёрдугаар, Батлан хамгаалах яамны захиалгаар Үндэсний батлан хамгаалахын их сургуульд докторын хөтөлбөрөөр суралцах докторанттай байгуулах гэрээний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлан хамгаалах яамны захиалгаар Үндэсний батлан хамгаалахын их сургуульд доктор бэлтгэх журмын дагуу элсэлтийг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах, гэрээ байгуулах асуудлыг яамны Төрийн захиргааны удирдлагын газар (хурандаа Р.Энхболд)-т даалгасугай.

3. Докторын өдрийн ангид суралцагчдыг цалинжуулах, сургалтын зардлыг зохих журмаар тооцож жил бүр төсөвт тусгахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга (бригадын генерал Д.Ганхуяг)-д зөвшөөрсүгэй.

4. Батлан хамгаалах яамнаас эрдэмтэн бэлтгэх бодлогыг 2030 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн явцыг жил бүрийн дөрөвдүгээр улиралд багтаан Сайдын зөвлөлийн, өдрийн ангид суралцагчдын судалгааны ажлын явцыг жил тутамд яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралдаанд тус тус танилцуулахыг Үндэсний батлан хамгаалахын их сургууль (бригадын генерал П.Жаргалан)-д хариуцуулсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж)-т даалгасугай.


САЙД



Г.САЙХАНБАЯР

1323100000

Батлан хамгаалахын сайдын 2023 оны
 11 дугаар сарын 24-ны өдрийн
 А/390 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНААС ЭРДЭМТЭН БЭЛТГЭХ БОДЛОГЫГ 2030 ОН ХҮРТЭЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах судлал, аюулгүй байдлын чиглэлээр эрдэм шинжилгээний ажил эрхлэх, судалгаа хийх, сургалт явуулах оюуны мэдлэг, чадавхтай эрдэмтдийн нөөц бүрдүүлэх, тэднийг сургаж бэлтгэх, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх, хөгжүүлэх, тогтвортой ажиллах нөхцөлийг хангаж, үр дүнтэй ашиглахад оршино

д/д	Сургах чиглэл	Элсэлт авах он, суралцуулах хүний тоо								Санхүүгийн зардал	Хариуцах байгууллага
		2024	2025	2026	2027	2028	2029	2030	Нийт		
Зорилт 1. яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөс зарласан сэдвийн хүрээнд 35 хүртэлх насны офицеруудыг сонгон шалгаруулж докторантурын өдрийн ангид 3 жилээр сургах											
1.	Цэргийн урлаг	2	2	1	1	2	2	1	13	Өдрийн ангийн докторантуудын цалин, сургалтын төлбөр	Батлан хамгаалах яамнаас санхүүжүүлнэ.
2.	Цэргийн зэвсэглэл, техник	2	1	1	1	2	2	1	12		
3.	Бусад ¹	1	2	3	3	1	1	3	15		
4.	Жилд нийт	5	5	5	5	5	5	5	40		

Цэргийн аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, батлан хамгаалах болон цэргийн боловсрол, цэргийн түүх, урлаг, анагаах зэрэг чиглэлээр

Зорилт 2. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага болон Төрийн цэргийн байгууллагуудын захиалгаар докторантуудыг суралцуулах

1.	Цэргийн шинжлэх ухаан	1	1	1	1	1	1	1	8	Өдрийн ангийн докторантуудын цалин, сургалтын төлбөр	Тухайн захиалагч байгууллага өдрийн ангийн докторантуудын цалин, сургалтын төлбөрийг хариуцан сургана.
2.	Аюулгүй байдал судлал	3	3	3	3	3	3	3	24		
3.	Бусад ²	1	1	1	1	1	1	1	8		
4.	Жилд нийт	5	5	5	5	5	5	5	40		

Зорилт 3. ҮБХИС-ийн докторын сургалтыг төгсөж, эрдмийн зэрэг хамгаалсан докторуудаас дотооддоо шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах офицеруудыг бодлогоор сонгон шалгаруулан Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах

1.	Цэргийн шинжлэх ухаан	1	2	1	2	1	2	1	12	Шинжлэх ухааны докторын зэргийн хамгаалалттай холбоотой зардал	Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсны дараа хамгаалалтын зардлыг БХЯ-наас нөхөн олгох
2.	Жилд нийт	1	2	1	2	1	2	1	12		

Зорилт 4. Гадаадын их, дээд сургуульд суралцуулах докторант, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах докторуудыг бэлтгэх

1.	Цэргийн урлаг	-	-	-	-	-	-	-	1	Доктор	Гадаад хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан гэрээний дагуу суралцуулна.
		1	1	1	-	1	-	-	5	Докторант	
2.	Цэргийн зэвсэглэл, техник	1	-	-	-	-	-	1	2	Доктор	
		1	1	-	1	1	1	1	7	Докторант	
3.	Бусад ³	-	-	-	-	1	-	-	1	Доктор	
		-	1	1	1	-	1	-	4	Докторант	
4.	Жилд нийт	1	1	-	-	1	-	1	4	Доктор	
		2	2	2	2	2	2	2	16	Докторант	

² Батлан хамгаалах судлал, цэргийн боловсрол, цэргийн түүх, урлаг, анагаах зэрэг чиглэлээр


³ Батлан хамгаалах болон цэргийн боловсрол, цэргийн түүх, урлаг, анагаах зэрэг чиглэлээр

Зорилт 5. ҮБХИС-ийн Эрдмийн сургуулийн докторантурын сургалтад төлбөртэй суралцах												
1.	Цэргийн шинжлэх ухаан	8	8	8	8	8	8	8	8	64	Докторантын сургалтын төлбөр, хамгаалалтын зардал	Тухайн суралцагч өөрөө хариуцна.
2.	Батлан хамгаалах судлал	8	8	8	8	8	8	8	8	64		
3.	Аюулгүй байдал судлал	20	20	20	20	20	20	20	20	160		
4.	Жилд нийт	36	36	36	36	36	36	36	36	188		

Тайлбар: Докторын сургалтын төлбөрийг ҮБХИС-ийн захирлын тушаалаар тухайн жилд баталж мөрдөнө.

...oOo...

Батлан хамгаалахын сайдын 2023 оны
1.1 дугаар сарын 24 ны өдрийн
А/340 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ЗАХИАЛГААР ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬД ДОКТОР БЭЛТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь БХЯ-ны захиалгаар Үндэсний батлан хамгаалахын их сургууль (цаашид “ҮБХИС” гэх)-д доктор бэлтгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. БХЯ-ны захиалгаар ҮБХИС-д доктор бэлтгэх журам (цаашид “доктор бэлтгэх журам” гэх) нь Дээд боловсролын тухай хууль, Засгийн газрын 2016 оны 156 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2010 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/370 дугаар тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, Батлан хамгаалахын сайдын 2023 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан “БХЯ-наас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлого”, “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм”-д үндэслэнэ.

1.3. Энэхүү журмаар “БХЯ-наас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд БХЯ-ны захиалгаар батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал судлалаар оюуны өндөр мэдлэг, чадавхтай эрдэмтдийг сургаж бэлтгэх, нөөц бүрдүүлэх асуудлыг зохицуулна.

1.4. БХЯ-ны захиалгаар жил бүр Сайдын тушаалаар баталсан мэргэжил, хяналтын тоогоор, төрийн алба хаагчийг элсүүлж ҮБХИС-ийн докторантурын өдрийн ангид сургана. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллага, Төрийн цэргийн байгууллагуудаас захиалга өгсөн тохиолдолд 3 хүртэл элсэгчийг суралцуулж болно.

1.5. БХЯ-ны захиалгаар суралцах офицер, төрийн алба хаагчийн суралцах хугацааны цалин, сургалтын зардлыг БХЯ хариуцна. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллага, төрийн цэргийн байгууллагуудын офицер, төрийн алба хаагчийн цалин, сургалтын зардлыг захиалагч байгууллага хариуцна.

Хоёр. Сонгон шалгаруулалт

2.1. БХЯ-ны ШУТЗ-нь батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал чиглэлээр эрдэм шинжилгээний ажил эрхлэх, судалгаа хийх, цаашид сургалт, эрдэм шинжилгээний байгууллагад тогтвор суурьшилтай ажиллах сонирхолтой магистрын зэрэгтэй офицер, төрийн алба хаагчдаас ҮБХИС-ийн докторантурт суралцуулахаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

2.2. Сонгон шалгаруулалт нь батлан хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх чиглэл, батлан хамгаалах эрэлт, хэрэгцээ, салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлттэй уялдсан, БХЯ-наас баримтлах эрдэмтэн бэлтгэх

бодлогыг удирдлага болгосон байна.

2.3. БХЯ-ны ШУТЗ сонгон шалгаруулалтын зарыг судалгааны ажлын сэдвийн хамт БХЯ-ны цахим хуудсанд байршуулж, өдөр тутмын хэвлэл, Соёмбо сонинд нийтлүүлнэ.

2.4. БХЯ-ны ШУТЗ нь яамны захиалгаар ҮБХИС-ийн докторантурт суралцах хүсэлтэй офицер, төрийн алба хаагчийн сонгон шалгаруулалтыг жилд 1 удаа 9 дүгээр сард зохион байгуулна.

2.5. Батлан хамгаалахын сайдын тушаалаар томилогдсон БХЯ-ны холбогдох албан тушаалтнууд, ҮБХИС-ийн эрдэмтэн, багш нарын төлөөлөл бүхий комисс элсэлтийн шалгалтыг авна.

2.6. Шалгаруулалтад тэнцсэн элсэгчид БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газартай суралцах тухай гэрээ байгуулах ба ҮБХИС-ийн докторантурт суралцуулах асуудлыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар шийдвэрлэнэ. Тушаалд суралцуулах хөтөлбөрийн нэр, хугацаа, сургах хэлбэрийг тодорхой заасан байна.

2.7. БХЯ-ны ШУТЗ үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллага, төрийн цэргийн байгууллагуудаас тухайн жилийн 8 дугаар сард санал авч, элсэлтийн шалгалтад оруулах асуудлыг шийдвэрлэнэ.

2.8. Сонгон шалгаруулалтад оролцох офицер, төрийн алба хаагчид нь элсэлтийн шалгалт буюу сонгон шалгаруулалтад оролцохдоо ҮБХИС-ийн “Магистр, докторын сургалтын журам”-ын дагуу бичиг баримтын бүрдүүлэлт хийж, Эрдмийн сургуулийн Сургалт, судалгаа хөгжүүлэлтийн албаар хянуулсны үндсэн дээр БХЯ-ны ШУТЗ-д хүлээлгэн өгнө.

2.9. Элсэлтийн шалгалт буюу сонгон шалгаруулалтыг ҮБХИС-ийн докторантурт мөрдөгдөж байгаа хөтөлбөрийн чиглэлийн дагуу зохион байгуулна.

Гурав. Сургалтын хугацаа, зохион байгуулалт

3.1. Докторантын сургалтын хугацаа 3 жил байна.

3.2. Сургалтын эхний хичээлийн жил нь 10 дугаар сарын 1-нд, дараа жилийн сургалтууд 9 дүгээр сарын 1-нээс эхэлнэ.

3.3. Докторант ҮБХИС-ийн Эрдмийн сургуульд харьяалагдаж, тус сургуулийн сургалтын болон үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу их сургууль дээр мөрдөгдөж буй дүрэм, журмыг удирдлага болгон суралцана.

3.4. Сургалтыг ҮБХИС-ийн Эрдмийн сургуульд хэрэгжүүлж байгаа докторын хөтөлбөрийн дагуу зохион байгуулах ба докторант нь хөтөлбөрийн хичээлийн багц цагийн шаардлагыг хангасны дараа нэгдсэн шалгалт өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд БХЯ-ны ШУТЗ-өөс зарласан сэдэв, чиглэлийн хүрээнд суралцагчийн диссертацийн сэдэв, эрдэм шинжилгээний ажлын удирдагчийг батална.

3.5. Докторантыг суралцах хугацаанд нь Эрдмийн сургуулийн төлөвлөгөөний

дагуу тус сургууль, их сургууль, БХЯ-ны захиалгат болон бусад эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажилд оролцуулах болон бакалавр, магистрын сургалтад 4 багц цаг хүртэл хичээл заалгаж болно.

3.6. Эрдмийн сургууль нь докторантын суралцаж буй байдал, судалгааны ажлын явцыг жил бүр үнэлж, дүгнэснээр дараачийн жилийн сургалтад хамруулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.7. Эрдмийн сургууль нь докторантын суралцах, судалгаа хийх орчин, нөхцөлийг бүрдүүлж, хичээл заах багш, эрдэм шинжилгээний удирдагчийг томилох, диссертацийн бүтцийн төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийн явц, үр дүнг тооцох, түвшин тогтоох, хичээлийн танхим, сургалтын техник хэрэгслээр хангах, нэгдсэн шалгалт өгөх, үнэлж дүгнэх, чөлөө олгох, сургуулиас хасах, диссертацийн хамгаалалтыг хийлгэх зэрэг асуудлыг БШУЯ болон ҮБХИС-д мөрдөгдөж буй холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулах үүрэг хүлээнэ.

3.8. БХЯ-ны ШУТЗ докторантын суралцаж буй байдал, судалгааны ажлын явцын талаарх тайланг жил бүр хэлэлцэж, зохих шийдвэрийг гаргана.

3.9. Докторант нь ҮБХИС-д мөрдөгдөж буй дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, сургалтын хөтөлбөрт бүрэн хамрагдаж, нэгдсэн шалгалтаа амжилттай өгөх, судалгааны ажлаа цаг хугацаанд нь гүйцэтгэж, үр дүнгээр нь боловсруулсан диссертациа сургалтын 3 дахь жилийн төгсгөлд хамгаалах үүргийг хүлээнэ.

3.10. Докторант хүндэтгэх шалтгаанаар цаг хугацаандаа диссертациа хамгаалж чадаагүй тохиолдолд диссертацийн хамгаалалт хийх хугацааг нэг жилээр сунгаж болох ба өөрийн зардлаар диссертацийн хамгаалалтаа хийнэ.


---oOo---

Батлан хамгаалахын сайдын 2023 оны

11 дугаар сарын 24-ны өдрийн

А/390 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ЗАХИАЛГААР ҮНДЭСНИЙ БАТЛАН
ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬД ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРӨӨР СУРАЛЦАХ
ДОКТОРАНТТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭ**



20... оны ... дугаар сарын ...

№

Улаанбаатар хот

Нэг талаас Монгол Улсын Батлан хамгаалах яамыг төлөөлж Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, нөгөө талаас Батлан хамгаалах яамны захиалгаар ҮБХИС-ийн Эрдмийн сургуульд элсэн суралцах болзлыг хангасан докторант

.....оршин суух хаягтай
.....регистрийн дугаартай

албан тушаалтай овогтой, нар Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2, Боловсролын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.1, тус хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.2, 47.1.3, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2015 оны А/363 дугаар тушаалаар батлагдсан “Гадаадын сургууль, дамжаанд суралцагчдыг сонгон шалгаруулах, суралцуулах журам”-ын 1.4 дэх хэсэг, мөн сайдын 2019 оны А/70 дугаар тушаалаар батлагдсан Батлан хамгаалахын хүний нөөцийн бодлогын баримт бичгийн 3.6 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/370 дугаар тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, Батлан хамгаалахын сайдын 2023 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан “БХЯ-наас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлого”, “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм” болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг тус тус үндэслэн харилцан тохиролцсоны үндсэн дээр дор дурдсан нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Батлан хамгаалах яам болон Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа Эрдмийн сургуульд докторын хөтөлбөрт элсэн суралцагч /цаашид докторант гэх/ хооронд гэрээгээр тусгайлан заах эрх, үүрэг, хариуцлагын хэм хэмжээг зохицуулахад оршино.

1.2. Батлан хамгаалах яамны захиалгаар ҮБХИС-ийн Эрдмийн сургуулийн өдрийн докторын ангид 3 жил суралцаж, докторын зэрэг хамгаалан Цэргийн мэргэжлийн сургалт, судалгааны байгууллагад гэрээгээр тогтвор суурьшилтай ажиллана.

1.3. Докторантын суралцах хөтөлбөр.....

ХОЁР.БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Батлан хамгаалах яамны эрх

2.1.1. Докторантын сурлага, сахилгын байдалд хяналт тавих, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.1.2. Докторантын суралцах үйл ажиллагаатай холбоотой үүрэг, даалгавар өгч биелэлтийг нь хангуулах;

2.1.3. Докторын сургалтын багц цагийг бүрэн хангагүй, эсвэл сургалтын багц цагийг бүрэн хангасан боловч сургалтын 3 дахь жилийн төгсгөлд докторын зэргээ хамгаалаагүй суралцагч, өөрийн хүсэлтээр сургуулиас хасагдсантай холбоотойгоор гарсан сургалтын төлбөр болон холбогдох бусад зардлыг төлүүлэхээр нэхэмжлэл гаргах;

2.1.4. Докторант сургалтын 3 дахь жилийн төгсгөлд докторын зэргээ хамгаалсаны дараа Цэргийн мэргэжлийн сургалт, судалгааны байгууллагад томилох.

2.2. Батлан хамгаалах яамны үүрэг

2.2.1. Докторантын суралцах нөхцөл, бололцоог хангуулах, хууль ёсны эрх ашгийг хамгаалах;

2.2.2. Докторантын суралцах хугацааны сургалтын зардал, хамгаалалтын зардал болон суралцах хугацаанд албан тушаалын цалингийн зэрэглэлээр цалинжуулах;

2.2.3. Докторантын суралцах хугацаанд холбогдох журмын дагуу цэргийн цолыг олгох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2.4. БХЯ-ны буруугаас суралцагчид хохирол учруулсан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу барагдуулах арга хэмжээ авах.

ГУРАВ. СУРГУУЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн эрх

3.1.1. Докторантаас гэрээгээр болон бусад дүрэм журмаар хүлээсэн үүргээ биелүүлэх, амжилттай суралцахыг шаардах;

3.1.2. Хууль ёсны үүрэг, даалгавар өгч биелэлтийг шалгах;

3.1.3. Хүлээсэн үүргээ биелээгүй тохиолдолд гэрээгээр болон дүрэм журамд заасан сахилгын болон бусад арга авч хариуцлага тооцох;

3.1.3. Дүрэм журамд заагдсан бусад хууль ёсны эрх.

3.2. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн үүрэг

3.2.1. Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулах;

3.2.2. Суралцах хугацаанд нь хичээлийн байр, танхим, спорт заал, соёлын төв, номын сан, интернэт, сургалт, эрдэм шинжилгээний лаборатори, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зэрэг сургалтад зайлшгүй шаардагдах орчин нөхцөлөөр хангах;

3.2.3. Сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлийг бүрэн эзэмшиж хамгаалалт хийсэн докторантад докторын зэрэг, диплом, энгэрийн тэмдэг олгох.

ДӨРӨВ. СУРАЛЦАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Суралцагчийн эрх

4.1.1. Хичээл, сургалтад шаардлагатай ном сурах бичиг, техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хэрэглэх, сурах бүх талын таатай орчноор хангагдах;

4.1.2. Сургалттай холбоотой асуудлаар сургуулийн удирдлага, холбогдох байгууллагад санал хүсэлтээ тавьж шийдвэрлүүлэх;

4.1.3. Сонсогч, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох, бүтээлээ үнэлүүлэх;

4.1.4.

4.2. Суралцагчийн үүрэг

4.2.1. ҮБХИС-ийн дүрэм, дотоод журмыг дагаж мөрдөх, сургууль, багш нарын зүгээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

4.2.2. Эх оронч үндэсний үзлийг дээдэлж, шамдан суралцан, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг бүрэн хангаж, өөрийгөө бие даан хөгжүүлэх;

4.2.3. Сургууль, тэнхим, сонсогч, оюутны байгууллагаас зохиож буй сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн ажил, арга хэмжээнд идэвх санаачилгатай, тасралтгүй оролцох;

4.2.4. Докторант судалгааны ажлын үр дүнгээ заасан хугацаанд сургууль, тэнхимд тайлагнаж байх;

4.2.5. Сургуулийн анги танхим, эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг ариг гамтай эдэлж хэрэглэх.

ТАВ. ДОКТОРАНТАД ЧӨЛӨӨ ОЛГОХ, ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

5.1. Ар гэрийн гачигдал, эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд докторантад 1 жилийн хугацаагаар чөлөө олгож болох бөгөөд чөлөөг суралцах хугацаанд нь зөвхөн 1 удаа олгох бөгөөд чөлөөг сунгахгүй.

5.2. Докторант хичээлээс чөлөө олгох хугацааг 36 цагаас хэтрэхгүй байхаар тооцно. Тэнхимийн дарга 2 хоногийн, харьяаллын сургуулийн захирал 4 хоногийн ҮБХИС-ийн захирал сургуулийн дүрэм, цэргийн дүрмээр тогтоосон хэм хэмжээг баримтлан докторантад чөлөө олгож болно.

5.3. Докторын сургалтын багц цагийг бүрэн хангаагүй шалтгаанаар нөхөн сургалтад хамрагдах тохиолдолд гарах зардлыг докторант өөрөө хариуцана.

5.4. Докторант сургалтын багц цагийг бүрэн хангасан боловч сургалтын 3 дахь жилийн төгсгөлд эсвэл 1 жилийн чөлөө авсаны дараагийн жилээс эхлэн 8 сарын дотор докторын зэргээ хамгаалаагүй тохиолдолд суралцсан хургацааны сургалтын төлбөр болон сургалтад зарцуулсан зардлыг нөхөн төлүүлнэ.

5.5. Өөрийн хүсэлтээр сургалтын явцад сургуулиас хасагдсан бол суралцсан хугацаанаас хасагдсан өдөр хүртэлх гарсан сургалтын төлбөр болон холбогдох бусад зардлыг нөхөн төлүүлэх;

5.6. Докторант өөрийн буруутай үйлдлээр сургалтад ашиглаж буй анги танхим, эд хөрөнгө, тоног төхөөрөмж, зэвсэглэл, техникийг эвдэлсэн, үрж шамшигдуулсан тохиолдолд үнийн дүнгээр тооцон хохирлыг 3 сарын дотор төлж барагдуулна.

ЗУРГАА. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ НӨХЦӨЛ

6.1. Сургууль нь докторанттай байгуулсан суралцах гэрээг дараах тохиолдолд цуцална.

6.1.1. Хичээлийн нэг улиралд 4 ба түүнээс дээш хичээлд “F” үнэлгээтэй болон хичээлийн жилийн эцсээр сурлагын голч дүн нь 2.0-доош үнэлгээтэй бол;

6.1.2. Төрийн хууль, тогтоомж, нийгмийн дэг журам зөрчиж, ёс бус үйлдэл гаргасан, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон;

6.1.3. Монгол Улсын хууль, цэргийн дүрэм болон ҮБХИС-ийн дүрэм, дотоод журмыг ноцтойгоор зөрчсөн.

6.1.4. Гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй бол;

6.1.5. Эрүүл мэндийн болон ар гэрийн гачигдлын шалтгаанаар үргэлжлүүлэн суралцах боломжгүй болсон нь нотлох баримтаар баталгаажсан тохиолдолд.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1. Энэ гэрээнд гурван тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2. Гэрээ нь докторын зэрэг хамгаалсан эсвэл гэрээг цуцалсан нөхцөлд хүчингүй болно.

7.3. Гэрээнээс үүдэлтэй аливаа маргааныг талууд хэлэлцээний замаар шийдвэрлэх боломжит бүхий л арга хэмжээг авна. Хэрэв уг арга хэмжээ нь зохих үр дүнд хүрэхгүй бол хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

7.4. Гэрээний сунгалтыг жил бүр дараах хүснэгтийн дагуу хийнэ.

№	Хичээлийн жил	Сунгагдсан эсэх	Суралцагчийн гарын үсэг	Сургуулийн тэмдэглэл	Тайлбар

ТАЛУУДЫН БАЙНГЫН ХАЯГ:

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энх тайвны өргөн чөлөө-51,

Засгийн газрын 7 дугаар байр

Суралцагчийн хаяг:

Шаардлагатай үед холбоо барих хүн,
хэн болох,.....
Утас:.....

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
...../ /

2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
...../ /

2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр

ҮБХИС-ИЙН ЭРДМИЙН СУРГУУЛИЙН ДОКТОРАНТ

...../.....
УТАС:Гэрийн..... Үүрэн

ЦАХИМ ШУУДАН:.....

БУСАД ХАЯГ:

2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр